



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/1378

Мандалговь

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар хурлын шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 21 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бөхийн барилдаан, Хурдан морины уралдаан, Сур болон Шагайн харваа, Урлагийн фестиваль зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Дээрх үйл ажиллагааг зохион байгуулах тусгай журам боловсруулан батлуулж, хариуцлагын гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.
3. Авч, хэрэгжүүлж буй ажлын явцын мэдээллийг тухай бүр нь танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Л.Баярсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

484210330